



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/77

Улаанбаатар хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн,  
удирдамж батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.28 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн бүртгэлийн санг хөтлөх, мэдээллийг шинэчлэх, ашиглах журмын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлтийн газар /Д.Төмөртоогоо/-т даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 12 сарын 27-ны өдрийн  
А/17 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт



**“Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн бүртгэлийн санг хөтлөх, мэдээллийг шинэчлэх, ашиглах журам”-ын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

Дарга: Д.Төмөртоогоо, Бодлого төлөвлөлтийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Б.Энхцэцэг, Төр, хувийн хэвшлийн түншлэл, тусгай зөвшөөрлийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Н.Эрдэнэцогт, Мэдээллийн технологийн программ хангамж, кибер аюулгүй байдлын бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн;

Н.Чимэдлхам, Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн;

Д.Уранчимэг, Эм хангамжийн байгууллагын тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн;

Д.Баярмаа, Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн;

Э.Мөнхмандах, Барилгын хөрөнгө оруулалт, их засварын асуудал хариуцсан мэргэжилтэн;

Б.Сансармаа, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт, баталгаажилт хариуцсан мэргэжилтэн;


Ц.Амаржаргал, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний судалгаа хариуцсан мэргэжилтэн;

Б.Батцоож, Нийслэлийн эрүүл мэндийн газрын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын асуудал хариуцсан мэргэжилтэн;

Б.Оюунцэцэг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн улсын ахлах байцаагч (зөвшилцсөнөөр);

Ч.Доржгүнсмаа, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын нэгдсэн холбооны менежер (зөвшилцсөнөөр).

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 02 сарын 24-ны өдрийн  
А/77 дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

### Зорилго.

Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн бүртгэлийн санг хөтлөх, мэдээллийг шинэчлэх, ашиглах журмын төсөл боловсруулах.

### Баримтлах зарчим:

1. Тусгай зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод, эзэмшиж, ашиглахад хялбар болгох;
2. Мэдээллийн нэгдсэн бүртгэлийн сан нь тоон болон чанарын мэдээлэл агуулсан байх
3. Мэдээллийг эрүүл мэндийн байгууллага байгуулах хэрэгцээнд үнэлгээ хийх, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход ашиглах.

### Үйл ажиллагааны чиглэл

1. Эрүүл мэндийн байгууллага байгуулах хэрэгцээг үнэлэх, тусгай зөвшөөрөл олгох, сунгахад үндэслэл болох мэдээллийн нэгдсэн бүртгэлийн сангийн бүтэц, мэдээллийн эх үүсвэрийг бусад мэдээллийн сангийн үйл ажиллагаатай уялдуулан тодорхойлох;
2. Захиргааны ерөнхий хуулийн 61, 62 дугаар зүйлд заасны дагуу нөлөөллийн шинжилгээ хийж, холбогдох танилцуулга боловсруулах, оролцогч талуудын дунд хэлэлцүүлэг, ярилцлага зохион байгуулах, цахим хуудсаар санал авах;
3. “Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн бүртгэлийн санг хөтлөх, мэдээллийг шинэчлэх, ашиглах журам”-ын төсөл боловсруулах;
4. “Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн бүртгэлийн санг хөтлөх, мэдээллийг шинэчлэх, ашиглах журам”-ын төслийг боловсруулж, холбогдох байгууллага, яамны газар, хэлтсээс санал авах, хамтрагч талуудын дунд хэлэлцүүлэг хийх.
5. Тушаалын төслийг яамны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, гарсан саналыг тусгаж, ХЗДХЯ-д хүргүүлэх

## **Хүрэх үр дүн**

1. “Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн бүртгэлийн санг хөтлөх, мэдээллийг шинэчлэх, ашиглах журам”-ын төслийг боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу нөлөөллийн шинжилгээ хийж, холбогдох танилцуулга боловсруулсан байна.
2. Тушаалын төслийг яамны Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж, гарсан саналыг тусган ХЗДХЯ-д хүргүүлсэн байна.
3. Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн бүртгэлийн сангийн агуулга, хөтлөх, шинэчлэх, ашиглах үйл ажиллагаа тодорхой болсон байна.

## **Гүйцэтгэх хугацаа**

1. “Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн бүртгэлийн санг хөтлөх, мэдээллийг шинэчлэх, ашиглах журам”-ын төслийг 2017 оны 3 дугаар сарын 20-ны дотор.